



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ,
ҮР ДҮН”-Д ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ГНАГ-2025/03-ШТА-НА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу
Цахим хуудас: www.open.audit.mn

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын **дарга,**
тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 цахим хуудас: Munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер М.Алтантуяа

Утас: 70442424 цахим хуудас: Altantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Азбаяр

Утас: 99061429 цахим хуудас: Azbayarb@audit.gov.mn

Аудитор Д.Даваадорж

Утас: 88953144 цахим хуудас: Davaadorbj@audit.gov.mn

Баянхонгор хот 2025 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.open.audit.mn

Тайланг хянасан

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Аудитын менежер М.Алтантуяа

Тайланг бэлтгэсэн:

Ахлах аудитор Б.Азбаяр
Аудитор Д.Даваадорж

2025 оны 5 дугаар сарын 20-ны өдөр

Уг тайланг УАГ-ын цахим хуудаснаас үзнэ үү:
www.open.audit.mn

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70442424 дугаарын утас, 70442584 дугаарын факсаар харилцана уу.

ХАЯГ:

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар, Нутгийн удирдлагын ордон,
Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум 64090,
Баянхонгор аймаг
Монгол Улс

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл....3
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ4
БҮЛЭГ 1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ, ХУУЛЬ БОЛОН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГОД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨСӨН ҮҮ?.....5
АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ БОДЛОГЫН ХЭЛТЭСИЙН ӨРГӨН БАРЬСАН ТӨСВИЙН ТӨСЛИЙГ ТӨСӨВ ХЭЛЭЛЦЭХ ҮЕД ӨӨРЧИЛЖ ХУУЛЬД НИЙЦЭХГҮЙ, ТӨСӨВЛӨЛИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ОРУУЛАН БАТАЛСАН БАЙНА. .Error!
Bookmark not defined.
1.1. Баянхонгор аймгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийг дунд хугацааны хөгжлийн бодлого, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөсөн байна.5
1.2. Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана гэсэн шаардлагыг бүрэн хангаагүй байна.8
БҮЛЭГ 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ТӨЛӨВЛӨСӨН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН УУ?11
2.1. Баянхонгор аймгийн орон нутгийн төсөв болон замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулсан байна.11
2.2. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд ажлын тоо хэмжээг тулгаагүйгээс илүү санхүүжилт олгосон байна.15
БҮЛЭГ 3. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ ҮР ДҮНТЭЙ БАЙНА УУ? 22
ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ ИРГЭДИЙН ТААТАЙ АМЬДРАХ ОРЧИНД ЭЕРЭГ НӨЛӨӨ ҮЗҮҮЛЖ БАЙНА.....22
3.1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар бий болсон зарим хөрөнгийн бүртгэл, ашиглалт хангалтгүй байна.23
3.2. Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж ашиглалтад орсон төсөл, арга хэмжээ нь хүүхдийн сурч, боловсрох болон иргэдийн ажиллаж, амьдрах орчинд эерэг нөлөө үзүүлж байна.23
ДҮГНЭЛТ: 26
ЗӨВЛӨМЖ: 27

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

Товчилсон үгийн тайлбар

АНТАГ	Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОН	Орон нутаг
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ХАА	Худалдан авах ажиллагаа
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн төсөвт үйлдвэрийн газар
ТШЗ	Тендер шалгаруулалтын зааварчилгаа
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал

Хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн уялдаа холбоо	5
Хүснэгт 2	2024 оны хөгжлийн төлөвлөгөөний уялдаа	7
Хүснэгт 3	Зураг төсөвгүй төлөвлөгдсөн төсөл арга хэмжээ	8
Хүснэгт 4	Зураг төсөвгүй төлөвлөгдсөн төсөл арга хэмжээ	8
Хүснэгт 5	Зураг төсөвгүй төлөвлөгдсөн төсөл арга хэмжээ	9
Хүснэгт 6	Хуулийн 13.1.1 дэх заалтыг зөрсөн төсөл арга	12
Хүснэгт 7	Эрх шилжүүлсэн ажлын жагсаалт	16
Хүснэгт 8	Төрийн болон орон нутгийн өмчийн барилгын их засварын хэрэгжилт	17
Хүснэгт 9	Замын сангийн ажлыг хэрэгжилт	20
10		

Зураглалын жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураглал 1	Жилийн хөгжлийн төлөвлөгөөний уялдаа	6
Зураглал 2	Худалдан авах ажиллагааны төрлөөр	11
Зураглал 3	Худалдаг авах ажиллагаа	14
Зураглал 4	Их засварын ажлын санхүүжилт	15
Зураглал 5	Авто замын сангийн ажлын санхүүжилт	17

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 5 дугаар тогтоолыг үндэслэн хийв.

Аудитын зорилт

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг Нийслэл дэх Төрийн аудитын газар болон аймгийн ИТХ, Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэв. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв.

- Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг, хууль болон орон нутгийн хөгжлийн бодлогод нийцүүлэн төлөвлөсөн эсэх.
- Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх
- Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл үр дүнтэй эсэх

Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллага, төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч аж ахуй нэгж, байгууллагын холбогдох үйл ажиллагааг хамруулан төлөвлөлт, судалгаа, шинжилгээний баримт материал, ажлын тайлан, төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл болон гэрээний хэрэгжилтэд төрийн захиргааны байгууллага, аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлд үндэслэн гүйцэтгэлийн аудитыг хийв.

Аудитын хязгаарлалт

Аудитад орон нутгийн төсвөөс 2024 онд хийгдэх төрийн болон орон нутгийн өмчийн барилга, байгууламжийн их засварын ажил, авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ, аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд туссан хөрөнгө оруулалтын шинж чанартай 2 төсөл арга хэмжээнээс бусад хөтөлбөр болон ОНХС-гийн хөрөнгө оруулалтыг хамруулаагүй болно.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг АДБОУБ(INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100, 300, 400, 3000-3001, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020, Гүйцэтгэлийн аудитын зарчим, 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, гүйцэтгэлийн аудит хийх аргачлалыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авч, харьцуулалт хийн, нэгтгэн, дүн шинжилгээ хийж, аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер М.Алтантуяа хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Азбаяр, аудитор Д.Даваадорж нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдрөөс эхлүүлж, аудитын гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2025 оны 4 дүгээр сарын 21-ээс 5 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, тайлагналын үе шатны ажлыг 2025 оны 5 дугаар сарын 11-ний өдрөөс эхлүүлж, тайланг 2025

Хүндрэл
бэрхшээл

оны 5 дугаар сарын 21-ний өдөр газрын дарга, тэргүүлэх аудитораар баталгаажуулан Нийслэл дэх Төрийн аудитын газар болон аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох бусад байгууллагуудад хүргүүлэв.
Байхгүй

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2024 оны их засвар, тоног төхөөрөмжийн жагсаалтыг батлахдаа өмнөх оноос шилжин хэрэгжиж байгаа 496.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 139.5 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 3 ТАХ, тайлант онд шинээр эхлэх 6,493.9 сая төгрөгийн өртөг бүхий 2,906.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 34 ТАХ хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Замын сангийн хөрөнгөөр 2024 онд 2,973.7 сая төгрөгийн өртөг бүхий 1,718.7 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 16 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр баталсан байна.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮН

БҮЛЭГ 1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ, ХУУЛЬ БОЛОН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГОД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨСӨН ҮҮ?

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь аймгийн Засаг даргаас өргөн барьсан төсвийн төслийг хэлэлцэх явцдаа төсөвлөлтийн шаардлага хангаагүй, хууль болон бодлогын баримт бичигтэй нийцээгүй төсөл, арга хэмжээг нэмэлтээр тусган баталснаас төлөвлөгөө тасарсан байна.

1.1. Төсөл арга хэмжээг, аймаг хөгжүүлэх дунд хугацааны бодлого болон Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр жилийн хөгжлийн төлөвлөгөөнд уялдуулан төлөвлөсөн үү?

1.1. Баянхонгор аймгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийг дунд хугацааны хөгжлийн бодлого, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөсөн байна.

1.1.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь аймаг хөгжүүлэх дунд хугацааны бодлогод уялдуулан төлөвлөсөн үү?

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 17/57 дугаар тогтоолоор баталсан 2024 оны орон нутгийн төсвийн болон замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ нь аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй уялдсан байна.

Хүснэгт №1 Аймаг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн уялдаа холбоо

Салбар	Төсөл, арга хэмжээ	Аймгийн засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Баянхонгор аймгийн хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	
1	Боловсролын салбар	Галуут, Богд, Хүрээмарал, Баянхонгор сумын 6, 12,11 дүгээр цэцэрлэг, Бууцагаан, Баянбулаг, Заг сумын сургуулийн барилга, Жаргалант, Өлзийт, Баацагаан, Гурванбулаг сумдын сургуулийн дотуур байрны их засвар.	Барилгын чанар, аюулгүй байдлыг сайжруулж, дотуур байр, гал тогоо, спорт болон урлагийн заалны хүртээмжийг нэмэгдүүлэх. (2.3.4-2.3.5)	Сургуулийн орчин сайжруулах, хүртээмж нэмэгдүүлэх (2.1.4, 2.1.5)
2	Биеийн тамир, спорт	Баянхонгор сумын Шинэ бүргэд боксын клуб, Шаргалжуут 8 дугаар баг, Баянбулаг,Баянцагаан, Бөмбөгөр сумдын спорт заалны их засвар	Спорт заалны ашиглалтыг сайжруулах, нийтийн биеийн тамир хөгжүүлэх. (2.2.3)	Нийтийн биеийн тамир хөгжүүлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх (3.3.3)
3	Эрүүл мэнд	Баян-Өндөр сумын эрүүл мэндийн төвийн их засвар	Эрүүл мэндийн байгууллагын чанартай, хүртээмжтэй үйлчилгээ хүргэх. (2.1.8)	Эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах (2.1.8)
4	Хууль, хүчний байгууллага	ЗХ-ний 339-р ангийн халуун ус, Жаргалант, Баянговь сумдын ОБ, Эрдэнэцогт, Гурванбулаг, Жаргалант сумын цагдаагийн барилгын засвар, Төрийн архивын галын аюулгүй байдлыг хангах системийн цэнэглэлт.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх. Архивын баримтын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах (4.4.1, 4.6)	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх (7.3.1, 7.3.3)
5	Соёлын салбар	Хөгжимт драмын театрын халаалтын шугамын засвар, Тэмүүжин театрын дээврийн засвар.	Соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагааг өргөжүүлэх (2.6.4)	Соёлын байгууллагын үйл ажиллагааг өргөжүүлэх (1.1.4)
6	Орон нутгийн хөгжил, дэд бүтэц	Баянхонгор сумын 6 дугаар багийн 30 айлын засвар, Номгон 1 дүгээр багийн 128 дугаар байрны их засвар, 314 дугаар байрны бохирын шугамын засвар, 314, 316 дугаар байрны дээврийн засвар	Барилга байгууламжийн нөхцөлийг сайжруулах (3.18.8)	Барилга байгууламжийн нөхцөлийг сайжруулах (8.1.9)

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

7	Эдийн засаг, нийгмийн хамгаалал	Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорацийн засвар, Ахмадын хорооны барилгын засвар.	Жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийг дэмжих. Жендер ба хөгжил хандлагыг төлөвшүүлэх (3.5, 2.8.4)	Эдийн засгийн бүтцийн шинэчлэл, ажлын байр нэмэгдүүлэх (4.1, 3.1.4)
8	Авто зам	Аймгийн төв доторх хатуу хучилттай зам шинэчлэх 1,95км	Иргэд ээлтэй, аюулгүй амьдрах, баталгаат орчныг бий болгоно (2.5)	Хатуу хучилттай авто зам, явган хүний зам, дугуйн зам, нийтийн эзэмшлийн зам, зогсоол барих, шинэчлэх (3.12.1)
9	Явган зам	Баянхонгор сумын Арван мянгатын дөрвөн замын уулзвараас Хонгор хотхон хүртэлх 0.7 км явган зам шинээр тавих	Нийтийн дэд бүтэц, ногоон байгууламж, усан сан, биеийн тамирын талбай, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх (2.5.3)	Аймгийн төв доторх явган хүний зам, дугуйн зам, нийтийн эзэмшлийн зам, зогсоол барих, шинэчлэх (3.12.1)
10	Зам, талбайн тохижилт		Ногоон байгууламж, амрах орчин, усан сан, биеийн тамирын талбай, зам бүхий тохилог орчныг бүрдүүлэх (2.5.3)	Авто замын тэмдэг тэмдэглэгээний засвар (3.12.3), нисэх буудлын хүчин чадал нэмэгдүүлэх (3.12.7), үерийн далан, хөрсний ус зайлуулах систем хэрэгжүүлэх (3.13.7)

Эх сурвалж: Аймгийн засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Баянхонгор аймгийн хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийх их засварын ажлууд болон замын сангийн хөрөнгө оруулалтаар 2024 онд 9,467.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 4,625.7 сая төгрөгийн санхүүжүүлэх дүнтэй 50 төсөл арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба аудитаар ИТХ-ын хуралдааны 2/6 дугаар тогтоолоор баталсан Баянхонгор аймгийн хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй уялдсан байдлыг авч үзэхэд батлагдсан төсөл арга хэмжээнүүд нь аймгийн дунд хугацааны бодлогод нийцсэн байна.

1.1.2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртэй нийцүүлэн төлөвлөсөн үү?

Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ нь Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртэй нийцсэн байна.

Зураглал №1. Жилийн хөгжлийн төлөвлөгөөний уялдаа



Аймгийн Засаг Даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын хуралдааны 2020 оны 2/7 дугаар тогтоолоор баталсан байна.

Орон нутгийн төсөв болон замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцсэн эсэхийг авч үзэхэд тайлант онд төлөвлөсөн 50 төсөл арга хэмжээнүүд нь Аймгийн Засаг Даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна.

1.1.3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг аймаг хөгжүүлэх жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаж байна уу ?

Батлагдсан төсөл арга хэмжээнүүд нь Баянхонгор аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаж төлөвлөгдсөн байна.

Хүснэгт №2. 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний уялдаа.

Салбар	Төсөл, арга хэмжээ	Баянхонгор аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө
Боловсролын салбар	Сургууль, цэцэрлэгийн барилга, дотуур байрны их засвар	Цэцэрлэгийн хүртээмжийг 4%-аар нэмэгдүүлнэ.
Биеийн тамир, спорт	Баянхонгор сумын Шинэ бүргэд боксын клуб, Шаргалжуут 8 дугаар баг, Баянбулаг, Баянцагаан, Бөмбөгөр сумдын спорт заалны их засвар	Стандартын шаардлага хангасан спортын орчныг 2%-аар нэмэгдүүлнэ
Эрүүл мэнд	Баян-Өндөр сумын эрүүл мэндийн төвийн их засвар	Эрүүл мэндийн хамрагдалтыг 2%-аар нэмэгдүүлнэ
Хууль, хүчний байгууллага	ЗХ-ний 339-р ангийн халуун ус, Жаргалант, Баянговь сумдын ОБ, Эрдэнэцогт, Гурванбулаг, Жаргалант сумын цагдаагийн барилгын засвар, Төрийн архивын галын аюулгүй байдлыг хангах системийн цэнэглэлт.	Цагдаагийн байгууллагын үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн түшинг 0.5 хувиар нэмэгдүүлнэ. Төр, засгийн ажил үйлчилгээний найдвартай ажиллах нөхцөлийг хангана Зэвсэгт хүчний цэргийн бэлэн байдлыг нэмэгдүүлнэ
Соёлын салбар	Хөгжимт драмын театрын халаалтын шугамын засвар, Тэмүүжин театрын дээврийн засвар.	Иргэдийн суурь хүмүүжил, төлөвлөлийн түшинг 10 хувиар нэмэгдүүлнэ.
Орон нутгийн хөгжил, дэд бүтэц	Баянхонгор сумын 6 дугаар багийн 30 айлын засвар, Номгон 1 дүгээр багийн 128 дугаар байрны их засвар, 314 дугаар байрны бохирын шугамын засвар, 314, 316 дугаар байрны дээврийн засвар	Иргэдийн олон талт хэрэгцээг хангасан орчныг 5 хувиар нэмэгдүүлнэ.
Эдийн засаг, нийгмийн хамгаалал	Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорацийн засвар, Ахмадын хорооны барилгын засвар.	Зорилтот бүлгийг хэрэгцээнд нийцсэн нийгмийн халамжийн үйлчилгээнд бүрэн хамруулна.
Авто зам	Аймгийн төв доторх хатуу хучилттай зам шинэчлэх 1,95км	Автозамын чанарын үзүүлэлтийг 8 хувиар сайжруулна. Суурьшлын бүс дэх орчны стандарт шаардлага хангасан талбайн хэмжээг 10 хувиар нэмэгдүүлнэ
Явган зам, Зам, талбайн тохижилт	Баянхонгор сумын Арван мянгатын дөрвөн замын уулзвараас Хонгор хотхон хүртэлх 0.7 км явган зам шинээр тавих	Суурьшлын бүс дэх орчны стандарт шаардлага хангасан талбайн хэмжээг 10 хувиар нэмэгдүүлнэ

Баянхонгор аймгийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөг ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 05-ний өдрийн 17/59 тоот тогтоолоор баталсан байна.

Жилийн хөгжлийн төлөвлөгөөнд батлагдсан 2024 онд орон нутгийн төсийн хөрөнгө болон замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 9,467.6 сая төгрөгийн 50 төсөл

арга хэмжээг Баянхонгор аймгийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдсан байна.

1.2. Төсөл арга хэмжээг, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн төлөвлөсөн үү?

1.2. Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана гэсэн шаардлагыг бүрэн хангаагүй байна.

1.2.1. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нь эерэг өөрчлөлт гарахуйц, хэрэгцээ шаардлагад тулгуурлан, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдолтой арга хэмжээ төлөвлөсөн үү?

Орон нутгийн төсвийн хөрөнгө, болон замын сангийн хөрөнгөөр шинээр хийгдэхээр төлөвлөгдсөн 9,467.6 сая төгрөгийн төсөл арга хэмжээ байгаагаас 3,057.0 сая төгрөгийн 14 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөхдөө Сангийн сайдын 2023 оны 278 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах” журмын 2.2.1, 2.2.2 дахь заалтын дагуу төсөл, арга хэмжээний саналыг холбогдох хууль, журам болон аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр үнэлэн, эрэмбэлж төлөвлөөгүй байна.

Аудитын илрүүлэлт:

Төсөл арга “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын дагуу үнэлж, эрэмбэлээгүй байна. Тухайлбал:

Нэг: Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс нь 2,271.5 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээг

1. Баянбулаг сумын сургуулийн их засвар.
2. Баянхонгор сумын 1 дүгээр багийн 128 дугаар байрны их засвар
3. Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн спорт заалны засвар
4. Баян-өндөр сумын эрүүл мэндийн төвийн засвар.
5. Баянцагаан сумын сургуулийн спорт заалны засвар
6. Гурванбулаг сумын сургуулийн дотуур байрны засвар
7. Бөмбөгөөр сумын спорт заалны засвар.

Хоёр: Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар нэмэлтээр 785.5 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээг эрэмбэллэгүй Баянхонгор аймгийн 2024 оны төсөвт оруулан тус тус баталсан байна.

Иймд орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг холбогдох хууль, журмын дагуу ач холбогдол, үр ашгийг дагуу эрэмбэлж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад өгөв.

1.2.2. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд ТЭЗҮ хийсэн, зураг төсвөө батлуулсан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн үү?

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээнүүд нь техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана гэсэн шаардлагыг бүрэн хангаагүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээнээс 4,621.7 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээг зураг төсөв,

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

техникийн тодорхойлолтыг хийлгэж, 4,845.9 сая төгрөгийн 18 төсөл арга хэмжээний зураг төсөвгүй төлөвлөсөн байна. Тухайлбал: Баянхонгор аймгийн 2024 оны төсөвт 1,871.9 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээг зураг төсөвгүй батлуулж төсөв батлагдсаны дараа зураг төсвийг хийлгэсэн байна.

Хүснэгт №3. Зураг төсөвгүй төлөвлөгдсөн төсөл арга хэмжээ

Төсөл арга хэмжээний нэр	Төсөв (сая төгрөг)	Зураг төсөв хийгдсэн огноо	Аймгийн төсөв батлагдсан огноо	Төсвийн тухай хуулийн 29.4 дэх заалттай нийцсэн эсэх
Баянбулаг сумын сургуулийн их засварын ажил	236.5	2024.01.17	2023.12.04	Нийцээгүй
Заг сумын сургуулийн засварын ажил	51.53	2024 он	2023.12.04	Нийцээгүй
Баянбулаг сумын спорт заалны засварын ажил	130.0	2024.01.19	2023.12.04	Нийцээгүй
Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн спорт заалны засварын ажил	190.0	2024.03.31	2023.12.04	Нийцээгүй
Баянцагаан сумын сургуулийн спорт заалны засварын ажил	620.0	2024 он	2023.12.04	Нийцээгүй
Баацагаан сумын сургуулийн дотуур байрны барилгын засварын ажил	525.5	2024 он	2023.12.04	Нийцээгүй
Баянхонгор сумын Арван мянгатын дөрвөн замын уулзвараас Хонгор хотхон хүртэлх 0.7 км явган зам шинээр тавих	119.4	2024 оны 1 сар	2023.12.04	Нийцээгүй
Нийт	1,871.9			

Зураг төсөв ор хийгдээгүй 2,811.0 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээ.

Хүснэгт №4. Зураг төсөвгүй төлөвлөгдсөн төсөл арга хэмжээ

Төсөл арга хэмжээний нэр	Төсөв (сая төгрөг)	Зураг төсөв хийгдсэн огноо	Аймгийн төсөв батлагдсан огноо	Төсвийн тухай хуулийн 29.4 дэх заалттай нийцсэн эсэх
Баянхонгор сумын 3-р сургуулийн баруун урд уулзвараас Арван мянгатын бетон зам хүртэлх 1 км авто зам тавих	2,049.0	Зураг төсөвгүй	2023.12.04	Нийцээгүй
Баянхонгор аймгийн Тэмүүжин театрын дээврийн засварын ажил	20.0	Зураг төсөвгүй	2023.12.04	Нийцээгүй
Баянхонгор сумын 314 дугаар байрны бохирын шугамын засварын ажил	20.0	Зураг төсөвгүй	2023.12.04	Нийцээгүй
Богд сумын цэцэрлэгийн барилгын засварын ажил	252.0	Зураг төсөвгүй	2023.12.04	Нийцээгүй
Бөмбөгөр сумын спорт заалны засварын ажил	40.0	Зураг төсөвгүй	2023.12.04	Нийцээгүй
Баянхонгор аймгийн хөгжимт драмын театрын халаалтын шугамын засварын ажил	430.0	Зураг төсөвгүй	2023.12.04	Нийцээгүй
Нийт	2,811.0			

Зураг төсөв хийгдээгүйгээс шалтгаалан 163.0 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Хүснэгт №5. Зураг төсөвгүй, хэрэгжээгүй төсөл арга хэмжээ

Төсөл арга хэмжээний нэр	Төсөв (сая төгрөг)	Зураг төсөв хийгдсэн огноо	Аймгийн төсөв батлагдсан огноо	Төсвийн тухай хуулийн 29.4 дэх заалттай нийцсэн эсэх
Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн гадна бохир усны шугам сүлжээний ажил	22.0	Зураг төсөв хийгдээгүй		Хэрэгжээгүй
Хүрээмарал сумын цэцэрлэгийн барилгын засварын ажил	65.0	Зураг төсөв хийгдээгүй		Хэрэгжээгүй
Заг сумын Засаг даргын тамгын газрын дээврийн засварын ажил	20.0	Зураг төсөв хийгдээгүй		Хэрэгжээгүй
Баянхонгор сумын 314, 316 дугаар байрны дээврийн засварын ажил	5.0	Зураг төсөв хийгдээгүй		Хэрэгжээгүй
Баянхонгор сумын 6 дугаар багийн 30 айлын засварын ажил	51.0	Зураг төсөв хийгдээгүй		Хэрэгжээгүй
Нийт	163.0			

Аудитын илрүүлэлт:

Аймгийн ИТХ-аар зураг төсөв, техникийн тодорхойлолт хийгээгүй 3,961.9 сая төгрөгийн 18 төсөл арга хэмжээг жилийн хөгжлийн төлөвлөгөө болон 2024 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төсөвт оруулан баталсан байна. Төсвийн тухай хуулийн 29.4¹, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3.3² дах заалтуудыг яагаад зөрчсөн талаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн холбогдох хэлтсээс тодруулахад бидний өргөн барьсан төсвийг ИТХ-д суудалтай намуудын бүлэг дээр задлан төсөвлөлтийн шаардлага хангахгүй эрэмбэлэгдээгүй төсөл, арга хэмжээг оруулан баталдаг гэсэн тайлбарыг өгсөн болно.

Иймд Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг батлахдаа ТЭЗҮ хийсэн төсөвлөлтийн шаардлага хангасан арга хэмжээг баталж байх асуудлыг Аймгийн ИТХ-д толилуулав.

1.2.3. Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөсөн үү?

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх 9,467.6 сая төгрөгийн 50 төсөл арга хэмжээг төлөвлөснөөс хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй 356.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 төсөл арга хэмжээг баталсан байна.

Аудитын илрүүлэлт:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3.2 дах заалтыг зөрчиж хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй дараах төсөл арга хэмжээг баталсан байна.

1. Баянхонгор сумын 6 дугаар багийн 30 айлын засварын ажил
2. Баянхонгор сумын 314, 316 дугаар байрны дээврийн засварын ажил
3. Баянхонгор сумын 1 дүгээр багийн 128 дугаар байрны их засварын ажил

Иймд хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төсөл арга хэмжээг төлөвлөхдөө төсөвлөлтийн шаардлага хангасан техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв

¹ Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг үйл ажиллагааг улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд хэрэгжүүлнэ.

² 13.3.3.техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ.

хийсэн, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөж байх албан шаардлагыг ЗДТГ-ын Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэст өгөв.

БҮЛЭГ 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ТӨЛӨВЛӨСӨН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН УУ?

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ 88.7 ХУВИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ БАЙГАА НЬ ТӨЛӨВЛӨСӨН 6 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙТЭЙ ХОЛБООТОЙ БАЙНА.

Баянхонгор аймгийн орон нутгийн төсөв болон замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулсан байна.

2.1 Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан уу?


2.1. Баянхонгор аймгийн орон нутгийн төсөв болон замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулсан байна.

2.1.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах, худалдан авах ажиллагааны журмыг сонгох үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан уу?

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг аймгийн Засаг дарга 2023 оны 11 дүрээр сарын 21-ний өдөр баталж тайлант хугацаанд 2 удаа тодотгосон байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийх 9,015.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 29 төсөл, арга хэмжээнээс 6,850,9 сая төгрөгийн 27 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг Аймгийн худалдан авах ажиллагааны газар нээлттэй болон харьцуулалтын тендер шалгаруулалтын аргаар зарлаж зохион байгуулсан байна.

Зураглал №2. Худалдан авах ажиллагааны төрлөөр.



Нээлттэй болон харьцуулалтын аргаар зохион байгуулсан тендерүүдийг Сангийн сайдын 2023 оны 248 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр худалдан авах ажиллагааг зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын хэрэгжилтийг бүрэн хангаж цахим системд тендерийн урилга, үр дүнг тухай бүр оруулан гүйцэтгэгчийг ил, тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган ажилласан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа 4 ТАХ-г худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанаас хоцроосон бол 2 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

Тухайлбал: Баянхонгор сумын 3-р сургуулийн баруун урд уулзвараас Арван мянгатын бетон зам хүртэлх 1 км авто замын ажлыг 2024 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн Аймгийн Засаг даргын А/94 захирамжаар Баянхонгор суманд эрх шилжүүлсэн боловч анх төсөв батлахдаа зураг төсөвгүй 1,200.0 сая төгрөгөөр аймгийн 2024 оны төсөвт батлуулсан, зураг төсвийг 2024 оны 01 дүгээр сарын 26-нд Баянхонгор сумын засаг дарга “Гео урбан консалтинг ХХК-р хийлгэн төсөвт өртөг 2,049.0 сая төгрөг болж ИТХ-ын хуралдааны 2024 оны 9 дүгээр сарын 16-ний өдрийн 21/06 дугаар тогтоолоор төсвийн тодотгол хийж баталсан нь худалдан авах ажиллагаа удаашрах, амжилтгүй болох гол шалтгаан болсон байна.

Хүснэгт №6. Хуулийн 13.1.1 дэх заалтыг зөрсөн төсөл арга хэмжээ.

Төсөл арга хэмжээ	Төсөв	Төлөвлөгөө	Худалдан авах ажиллагаа	Тайлбар
Баянхонгор сумын 6 дугаар багийн 30 айлын засварын ажил	51.0	2024.03.26	Зохион байгуулаагүй	Зураг төсөв хийгдээгүй
Баянхонгор сумын 3-р сургуулийн баруун урд уулзвараас Арван мянгатын бетон зам хүртэлх 1 км авто зам тавих	2049.0	2024.02.19	2024.08.16	Худалдан авах ажиллагааг 8,9 сар дээр 2 удаа зарлаж оролцогч оролцоогүй
Хүрээмарал сумын цэцэрлэгийн барилгын засварын ажил	65.0	2024.11.22	Зохион байгуулаагүй	2024.09.16-ний төсвийн тодотголоор шинээр нэмэгдсэн.
Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн спорт заалны засварын ажил	190.0	2024.02.26	2024.10.30	Зураг төсөвгүй худалдан авах ажиллагааны газар худалдан авах ажиллагааг аажуу зарласан.
Гурванбулаг сумын сургуулийн дотуур байрны засварын ажил	710.0	2024.02.23	2024.05.31	Гурванбулаг сумын ЗДТГ худалдан авах ажиллагааг хугацаа хоцроож зарласан
Бөмбөгөр сумын спорт заалны засварын ажил	40.0	2024.04.01	2024.11.29	Зураг төсөвгүй худалдан авах ажиллагааны газар худалдан авах ажиллагааг аажуу зарласан.
ДҮН	3,105.0			

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1³ дэх заалтыг зөрсөн байна.

Иймд цаашид худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа Төрийн хэмнэлийн хууль болон бусад хууль тогтоомжоор заасан хугацаанд багтаан худалдан авах ажиллагааг зохион байгуулж байх зөвлөмжийг аймгийн аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Зураг төсөвгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг аймгийн ИТХ-аар баталснаар аймгийн Засаг даргын 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд оруулсан нь тендер сонгон шалгаруулалтыг удаашруулах, амжилтгүй болгох, улмаар төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэл үүсэхээр байна

Иймд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд зураг төсөв нь батлагдсан, техникийн баримт бичиг нь бүрдсэн төсөл арга хэмжээг сонгон Төсвийн тухай хуульд нийцүүлэн баталж байх зөвлөмжийг Аймгийн засаг даргад өгөв.

2.1.2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулж, батлуулсан уу?

Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь тайлант онд 27 төсөл арга хэмжээний сонгон шалгаруулалтын тендерийн баримт бичигт тендерт оролцогчид тавих шаардлага, заавар, шалгаруулах шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, тендерийн жишиг маягыг боловсруулж тендер тус бүрийн үнэлгээний хорооны хурлаар баталсан байна.

Үнэлгээний хороо нь орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх 3 төсөл арга хэмжээний тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулан сонгон шалгаруулалтыг дахин зохион байгуулсан байна. Тухайлбал: Баян-өндөр сумын Эрүүл мэндийн төв, Баацагаан сумын сургуулийн дотуур байрны барилгын засварын ажилд оролцогчийг сонгон шалгаруулах ажиллагааг тус бүр 4 удаа зарласан боловч оролцогч ирээгүй тул тендерийн баримт бичгийн санхүүгийн чадавх тооцох шалгуурт өөрчлөлт оруулан дахин зарласан байна.

Баянхонгор Аймгийн Хөгжимт драмын театрын халаалтын шугамын засварын ажлын худалдан авах ажиллагааны Тендерийн бичиг баримтыг 2024 оны 01 дүгээр сарын 12-ний өдөр үнэлгээний хороо боловсруулж Тендерийн бичиг баримтын 19.2.1-д инженер, техникийн ажилтнуудын 66 ба түүнээс доошгүй хувь нь тухайн байгууллагын үндсэн ажилтан байх шаардлагыг оруулсан, Анхны тендер шалгаруулалтад оролцсон Мөнх Од конкрет ХХК нь энэ шалгуурыг хангаагүй ба


³ 13.1.1. батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах;

үнэлгээний хороо Тендерийн бичиг баримтыг дахин боловсруулан дээрх заалтын 66 хувь гэснийг 33 хувь болгож өөрчлөлт оруулан тендерийг хуулийн хугацаанд нь дахин зарлаж Мөнх Од конкрет ХХК-ыг шалгаруулсан байна.

2.1.3. Худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журам, тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан уу?

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжих 9,015.8 сая төгрөгийн төсөв өртөг бүхий 29 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зарлахаас 6,850.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 26 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагааг хуулийн дагуу амжилттай зохион байгуулж 6,689.2 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан бөгөөд худалдан авах ажиллагааны үр дүнгээр бага үнийн саналаар шалгаруулж 161.7 сая төгрөгийн хэмнэлт гарах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Зураглал №3. Худалдан авах ажиллагаа.



Орон нутгийн төсөв болон замын сангийн хөрөнгөөр 2024 он шинээр хэрэгжүүлэх 26 төсөл арга хэмжээнд нээлттэй болон харьцуулалтын аргаар тендер шалгаруулалтыг явуулсны дүнд 25 төсөл арга хэмжээг хууль, журам, тендерийн бичиг баримтад тусгасан шалгуур хангасан орооцогчийг шалгаруулж гэрээ байгуулсан байна.

Харин Жаргалант сумын сургуулийн дотуур байрны засварын ажлын тендер шалгаруулалтыг тендерийн бичиг баримтад заасан шаардлагыг хангаагүй оролцогчийн шалгаруулж гэрээ байгуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

Жаргалант сумын дотуур байрны засварын ажлын тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1 болон Өгөөгдлийн хүснэгтийн 19.1.3-т заасны дагуу оролцогч нь 2022 эсхүл 2023 онд барилга угсралт болон барилгын засварын ажлыг үндсэн гүйцэтгэгчээр гүйцэтгэсэн байх шаардлагыг хангасан байна гэж заасан байхад шалгарсан “Тэнгэрийн уул” ХХК нь тухайн хугацаанд зөвхөн явган хүний замын хашлага суурилуулах буюу гадна тохижилтын ажил гүйцэтгэсэн нь Барилгын тухай хуулийн 4.1.25-д заасан “гадна тохижилтын ажил”-д хамаарах бөгөөд барилгын ажил (4.1.11) гэж үзэх үндэслэлгүй байна. Иймд тус компани нь тендерийн ижил төстэй ажлын шалгуурыг хангаагүй байхад шалгарсан нь тендерийн баримт бичгийн шаардлагыг зөрчсөн байна.

Цаашид тендерийн баримт бичигт туссан ерөнхий шаардлагыг үнэлэх талаар үнэлгээний хорооны гишүүдэд арга, зүйн зөвлөгөө өгч ажиллахыг зөвлөмжийг Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнд хийсэн нийцлийн аудитаар аймгийн Худалдан авах ажиллагааны газрын даргад хүргүүлсэн болно.

2.2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн хүлээн авсан уу?

2.2. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд ажлын тоо хэмжээг тулгаагүйгээс 42,4 сая төгрөгийн илүү санхүүжилт олгосон байна.

2.2.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн хууль журмын дагуу санхүүжүүлсэн үү?

❖ Төрийн болон орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засвар

Аймгийн ИТХ-ны хуралдааны 2024.09.16-ны өдрийн 21/06 дугаар тогтоолоор төсөв тодотгол хийж орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төрийн болон орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засварын 6,990.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажилд нийт 3,051.5 сая төгрөгийн 37 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр баталснаас 6,663.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 32 ажил гүйцэтгэх гэрээ байгуулж 3,552.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Зураглал №4. Их засварын ажлын санхүүжилт



Аудитаар төсөл, арга хэмжээ тус бүрийг газар дээр нь ажлын гүйцэтгэлийг санхүүжилтийн баримтаар гаргасан гүйцэтгэлтэй тулган шалгахад ажил бүрээр хяналтын хуудас хөтөлж, зохиогчийн болон захиалагчийн хяналтын тайлан, ил, далд ажлын актыг баримтжуулан фото зургаар баталгаажуулан санхүүжилтийг хянаж

олгосон байна. /Төсөл, арга хэмжээ тус бүрээр санхүүжилтийн гүйцэтгэлийг хавсралт судалгаагаар харуулав./

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 289.8 сая төгрөгийн 6 их засварын ажлыг хэрэгжүүлэхээр эрх шилжүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт№ 7. Эрх шилжүүлсэн ажлын жагсаалт.

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /сая төгрөг/	Эрх шилжүүлсэн байгууллага
1	Заг сумын сургуулийн засварын ажил	51.5	Заг сумын Засаг дарга
2	Зэвсэгт хүчний 339-р ангийн халуун усны барилгын их засварын ажил	38.3	Зэвсэгт хүчний 339-р анги
3	Жаргалант, Баянговь сумын Онцгой байдлын газрын засварын ажил	20.0	Жаргалант, Баянговь сумын Засаг дарга
4	Эрдэнэцогт сумын цагдаагийн кабоны засварын ажил	15.0	Эрдэнэцогт сумын Засаг дарга
5	Гурванбулаг, Жаргалант суманд байрлах сум дундын цагдаагийн барилгын засварын ажил	20.0	Гурванбулаг, Жаргалант сумын Засаг дарга
6	Гурванбулаг сумын сургуулийн дотуур байрны засварын ажил	145.0	Гурванбулаг сумын Засаг дарга
	Нийт дүн	289.8	

Аудитын илрүүлэлт:

➤ Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн барилгын дээврийн ажлыг 42.4 сая төгрөгөөр хийсэн гэх байдлаар гүйцэтгэл гаргасан бөгөөд дээвэрт ажил хийгээгүй байхад хяналгүйгээр санхүүжилт олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5⁴, Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын 2.1.6⁵ дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн засварын хийгээгүй ажлын 42.4 сая төгрөгийг гүйцэтгэгч “Сувдан сондор цамхаг” ХХК-аар орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.


❖ **Авто замын сан**

Авто замын сангийн хөрөнгөөр 2024 оны 902.1 сая төгрөгийн 14 ажилд гэрээ байгуулж 848.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

⁴ 16.5.5. батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

⁵ 2.1.6.Хууль, журмын шаардлага хангасан төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтийн эрхийг нээх, шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтийг олгохгүй байх

Зураглал №5. Авто замын сангийн ажлын санхүүжилт



Аудитаар төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байдал, гүйцэтгэлийн хувь, холбогдох акт, санхүүжилтийн баримтуудыг талбарын ажилтай тулган шалгахад гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилтийг олгосон байна.

2.2.2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгүүлсэн үү?

2024 онд санхүүжүүлэхээр баталсан төсөл арга хэмжээнээс 9,799.5 сая төгрөгийн 34 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, 803.3 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт № 8. Төрийн болон орон нутгийн өмчийн барилгын их засварын ажлын хэрэгжилт

№	Төсөл арга хэмжээний нэр	Нөхцөл байдал
1	Жаргалант сумын орон сууцуудын дунд нийтийн эдэлбэр талбайд хүүхдийн тоглоомын талбай байгуулах Гэрээний дүн: 146.4 сая Гүйцэтгэгч: "Ерөөл нэмэх" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Нийтийн эзэмшлийн талбайд тоглоомын талбайг барьж ажлыг хүлээлгэн өгсөн. Явган зам, авто зогсоол, элсний талбай, Сагсан бөмбөгийн талбай, спорт тоглоомын талбай, ногоон байгууламж, сүүдрэвч тоног төхөөрөмжийн ажил хийж гүйцэтгэсэн.
2	Богд сумын хүүхдийн цэцэрлэгийн барилгын гадна засвар Гэрээний дүн: 89.7 сая Гүйцэтгэгч: "Түйн долгион" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Гадна заслын ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд тайлант онд үлдэгдэл санхүүжилтийг авсан.
3	Баянбулаг сумын спорт цогцолбор, цэцэрлэгт хүрээлэнгийн ажил Гэрээний дүн: 257.1 сая Гүйцэтгэгч "Шинэ өлгийн зам" ХХК Гүйцэтгэл: 0 хувь	Ажил удааширсан он дамжин гүйцэтгэж байгаа.
4	Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн барилгын их засварын ажил Гэрээний дүн: 570.6 сая Гүйцэтгэгч: "Содон сондор цамхаг" ХХК Гүйцэтгэл: .. хувь	Цонх болон хаалга, гадна металл фасад хийж гүйцэтгэсэн. Дээврийн ажил хийж гүйцэтгэсэн гэж гүйцэтгэлийн 42.4 сая төгрөгөөр гаргасан боловч дээвэрт ажил хийгээгүй.
5	Галуут сумын цэцэрлэгийн их засварын ажил Гэрээний дүн: 454.7 сая Гүйцэтгэгч: "Буян арвижих од" ХХК Гүйцэтгэл: хувь	Тус ажлын гэрээг 2024.10.08-нд байгуулсан бөгөөд дотор хаалга солих ажил хийсэн. Гэрээний хугацаа 2025.08.23-нд дуусна.
6	Баянхонгор сумын 12 дугаар цэцэрлэгийн их засварын ажил Гэрээний дүн: 382.5 сая Гүйцэтгэгч: "Буян арвижих од" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Дээврийн ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн. Гадна заслыг чулуун замаскаар хийсэн бөгөөд халаалтын ажлыг бүрэн шинэчилсэн. Ажлыг 2024.12.03-нд комиссоор хүлээлгэн өгсөн.
7	Бууцагаан сумын хуучин сургуулийн засварын ажил Гэрээний дүн: 356.6 сая Гүйцэтгэгч: "Түйн долгион" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Хаалга, цонх шал, дотор засал, шатны ажлыг хийсэн. Ажлыг 2025 онд хүлээлгэн өгсөн.

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

8	Богд сумын цэцэрлэгийн барилгын засварын ажил Гэрээний дүн: 248.7 сая Гүйцэтгэгч: "Түйн долгион" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Хаалга, цонхны ажил, шалны ажил, дотор заслын ажил, халаалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Шатны ажил хийж гүйцэтгэх ажил хийхээр төсөвт туссан боловч газар дээр нь очиж шалгахад ажил хийгээгүй байна.
9	Баянбулаг сумын сургуулийн их засварын ажил Гэрээний дүн: 232.3 сая Гүйцэтгэгч: "Хүрэн жинсний овоо" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Хуучин сургуулийн барилгын гадна фасадын ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд тоо хэмжээг дутуу тооцооноос дотор заслын ажлыг нэмж гадна фасадын ажил оруулсан. Гадна металл фасадын амлагааг завсар зай ихтэй хийснээс зай завсартай хийсэн.
10	Жаргалант сумын дотуур байрны засварын ажил Гэрээний дүн: 215.3 сая Гүйцэтгэгч: "Тэнгэрийн уул" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Хаалга цонх дотор талын шилэн хаалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. 2024,07,09-нд ажлыг комиссоор хүлээлгэн өгсөн.
11	Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорацийн засварын ажил Гэрээний дүн: 172.3 сая Гүйцэтгэгч: "Даяар трейд" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Оёдлын цех байгуулах зорилгоор тус барилгын 2 давхрын баруун жигүүрт шал, дотор засал, гэрэлтүүлэг салхивч тусгаарлах ажлыг хийж гүйцэтгэсэн.
12	Өлзийт сумын дотуур байрны засварын ажил Гэрээний дүн: 147.4 сая Гүйцэтгэгч: "Густокек" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Дотор халаалт гэрэлтүүлэг, гадна заслын ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд гадна эмульсийг дахин хийхээр үүрэг даалгавар өгсөн байна.
13	Ахмадын хорооны барилгын засварын ажил Гэрээний дүн: 143.5 сая Гүйцэтгэгч: "Даяар трейд" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Металл каркас, шал, дотор гадна заслын ажил дотор гэрэлтүүлэгчийн ажил хийсэн ба гадна заслын ажлыг 2 хэсэг жижиг өргөтгөл хийсэн.
14	Заг сумын сургуулийн засварын ажил Гэрээний дүн: 51.3 сая Гүйцэтгэгч: "Буянт хөрс наран" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Хаалга, цонх, шал, дотор засал, шат, довжоо, дотор гэрэлтүүлэг зэрэг хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн байна.
15	Баянхонгор сумын 6 дугаар багийн 30 айлын засварын ажил	Хэрэгжээгүй
16	Зэвсэгт хүчний 339-р ангийн халуун усны барилгын их засварын ажил Гэрээний дүн: 38.2 сая Гүйцэтгэгч: "Зэвсэгт хүчний 339-р анги" Гүйцэтгэл: 100 хувь	Цэргүүдийн усанд орон халуун усны өрөөг шинээр тоноглож дотор заслын ажлыг бүрэн хийсэн.
17	Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн гадна бохир усны шугам сүлжээний ажил	Хэрэгжээгүй
18	Баянхонгор аймгийн төрийн архивын аюулгүй байдлыг хангах галын хийн системийн цэнэглэлт үйлчилгээ Гэрээний дүн: 20.0 сая Гүйцэтгэгч: "Бэнжцэс" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Гал унтраах тоног төхөөрөмж, багаж техник хэрэгсэл авсан байна. Жагсаалтаар тоо хэмжээг тулгахад тохирч байв.
19	Жаргалант, Баянговь сумын Онцгой байдлын газрын засварын ажил Гэрээний дүн: 20.0 сая Гүйцэтгэгч: "Онцгой байдлын газар" Гүйцэтгэл: 100 хувь	Жаргалант сум: Гадна авто зогсоол, дотор халаалтыг хэсэгчлэн засварлаж, гадна хаалга сольсон Баянговь сум: Дотор хаалганууд сольсон дотор заслын ажил хийж гүйцэтгэсэн
20	"Шинэ бүргэд" боксын сургалтын заалны засварын ажил Гэрээний дүн: 19.0 сая Гүйцэтгэгч: "Энх цоо хишиг" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Нийт 89,6 м.кв талбай бүхий 3 хэсэг өрөөнд хана, тааз, шал, цахилгааны монтаж, гэрэлтүүлэг тавиур, шүүгээ, толь, хөшиг, тохижилт гэрэлт самбар, хаяг зэргийг хийж гүйцэтгэсэн.
21	Эрдэнэцогт сумын цагдаагийн барилгын засварын ажил Гэрээний дүн: 15.0 сая Гүйцэтгэгч: Б.Батсайхан Гүйцэтгэл: 100 хувь	170 м2 талбай бүхий дээврийг будах, гадна эмульс хийх, дотор лампиран тааз, гэрэлтүүлэг лого, Гадна бүргэд хаалга 2 ширхэг, дотор модон хаалга 2 ширхэг дотор обой үүдний тамбар дээврийг гэх мэт бусад засвар үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэсэн.
22	Гурванбулаг, Жаргалант суманд байрлах сум дундын цагдаагийн барилгын засварын ажил Гэрээний дүн: 20.0 сая Гүйцэтгэгч: Цагдаагийн газар Гүйцэтгэл: 100 хувь	Гурванбулаг сум: Кабоны дотор заслын ажил хийсэн. Жаргалант: Хурлын ширээ сейф сандал бусад эд хогшил авсан.
23	Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн Баянхонгор аймаг дахь салбарын барилгын засварын ажил Гэрээний дүн: 10.0 сая Гүйцэтгэгч: "БМБЖБ" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Халаалтын шугам солих ажлыг хийж гүйцэтгэсэн.
24	Баянхонгор аймгийн хөгжимт драмын театрын халаалтын шугамын засварын ажил Гэрээний дүн: 415.1 сая Гүйцэтгэгч: "Мөнх од конкрет" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Дулааны салбар 1-4 шугамын ажлыг хийж гүйцэтгэсэн. Дулааны узелийн ажил хийж гүйцэтгэсэн. Хуваарилах коллекторын ажил хийж гүйцэтгэсэн.

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

25	Баянхонгор сумын 1 дүгээр багийн 128 дугаар байрны их засварын ажил Гэрээний дүн: 300.0 сая Гүйцэтгэгч: "Содон сондор цамхаг" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	128 дугаар байрны орцны дотор заслын ажил, барилгын гадна фасад дээврийн ажил болон хонгилын бохирын шугамын ажлыг хийж гүйцэтгэсэн.
26	Баянбулаг сумын спорт заалны засварын ажил Гэрээний дүн: 130.0 сая Гүйцэтгэгч: "Эх бүрдэн" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Гадна заслын ажлын хүрээнд - үүдний хэсгийн довжоо шат болон гадна дээврийн хүрээ хадах ажил хийсэн Дотор заслын ажлын хүрээнд - рекээр доторлогоо хийсэн, хаалга сольсон Дээврийн ажлын хүрээнд дотор таазанд хөөсөн дулаалга хийсэн байна. 2024.10.15-ны өдрийн 2024/29 дугаар актаар хүлээн авсан.
27	Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн спорт заалны засварын ажил Гэрээний дүн: 190.0 сая Гүйцэтгэгч: "МАДОКА" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Хаалга цонх, дотор засал, шалны ажил, гадна заслын ажлыг хийж гүйцэтгэсэн. Ажлыг 2025 он гаргаж хүлээлгэн өгсөн.
28	Баян-өндөр сумын эрүүл мэндийн төвийн засварын ажил Гэрээний дүн: 175.0 сая Гүйцэтгэгч: "Елбата" ХХК Гүйцэтгэл: 83 хувь	Хяналтын төсөвт Гадна засал, бохир усны шаазан угаалтуур, шалны ажил, дээврийн ажил хийхээр төлөвлөсөн боловч аудитаар газар дээр нь очиж шалгахад төсвийн зориулалтыг зөвшөөрөлгүй өөрчилсөн ажил хийж дуусаагүй. 140,0 сая төгрөгийн гүйцэтгэл гаргасан.
29	Баянцагаан сумын сургуулийн спорт заалны засварын ажил Гэрээний дүн: 620.0 сая Гүйцэтгэгч: "Содон сондор цамхаг" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Шат, шал, хаалга, цонх, гадна, дотор засал, цахилгаан гэрэлтүүлэг, халаалт, салхивчийн ажил хийж гүйцэтгэсэн.
30	Баацагаан сумын сургуулийн дотуур байрны барилгын засварын ажил Гэрээний дүн: 525.5 сая Гүйцэтгэгч: "Баян улаан констракшн" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Хаалга, цонх, шал, гадна дотор засал, шат, гэрэлтүүлэг, дотор халаалт, салхивчийн ажлыг хийж гүйцэтгэсэн.
31	Гурванбулаг сумын сургуулийн дотуур байрны засварын ажил Гэрээний дүн: 677.0 сая Гүйцэтгэгч: "Гал гэрэл констракшн" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Хаалга цонх, дотор засал, шалны ажил, гадна заслын ажлыг хийж гүйцэтгэсэн. Ажлыг 2025 он гаргаж хүлээлгэн өгсөн.
32	Бөмбөгөр сумын спорт заалны засварын ажил Гэрээний дүн: 39.8 сая Гүйцэтгэгч: "Могон хөндий" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Биеийн тамын багшийн өрөөний хаалга, дотор 2 ширхэг сагсны шит, үүдний хэсгийн шалны наадаг хулдаас, шалны будаг хийсэн.
33	Хүрээмарал сумын цэцэрлэгийн барилгын засварын ажил	Хэрэгжээгүй
34	Баянхонгор аймгийн Тэмүүжин театрын дээврийн засварын ажил Гэрээний дүн: 20.0 сая Гүйцэтгэгч: "Түйн долгион" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Дээврийн засварын ажлыг хийж 2024.10.18-ны өдөр гэрээг дүгнэж санхүүжилтийг олгосон байна.
35	Заг сумын Засаг даргын тамгын газрын дээврийн засварын ажил	Хэрэгжээгүй
36	Баянхонгор сумын 314, 316 дугаар байрны бохирын шугамын засварын ажил Гэрээний дүн: 20.0 сая Гүйцэтгэгч: "Чандмань - Баянхонгор" ХК Гүйцэтгэл: 100.0 хувь	Хуучин шугамыг хуванцар шугамаар сольж тоногдсон байна.
37	Баянхонгор сумын 314, 316 дугаар байрны дээврийн засварын ажил	Хэрэгжээгүй

Аудитаар дээрх төсөл арга хэмжээнүүдэд ажиллахад дараах төрлийн зөрчлүүд

илрэв. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

➤ Баянбулаг сумын хуучин сургуулийн барилгын гадна фасадын ажлыг Хүрэн жинсний овоо ХХК гүйцэтгэсэн бөгөөд тоо хэмжээг төсөв зохиогч дутуу тооцоноос дотор заслын ажлыг нэмж

гадна фасадын ажил оруулсан. Гадна металл фасадын амлагааг завсар зай ихтэй хийснээс зай завсартай хийсэн.

- Эрдэнэцогт сумын цагдаагийн барилгын засварын ажлын хүрээнд 170 м2 талбай бүхий дээврийг будах, гадна эмульс хийх, дотор лампиран тааз, гэрэлтүүлэг лого, Гадна бүргэд хаалга 2 ширхэг, дотор модон хаалга 2 ширхэг дотор обой үүдний тамбар дээврийг гэх мэт бусад засвар үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэсэн боловч ашиглалтын явцад эвдэрч хэмхэрч байгаа талаар цагдаагийн үүрэг гүйцэтгэгч мэдэгдсэн. Энэ нь Барилгын тухай хуулийн 40.1.2⁶ дахь заалтыг зөрчсөн байна.

Иймд Баянбулаг сумын хуучин сургуулийн барилгын гадна фасад болон Эрдэнэцогт сумын цагдаагийн байрны засварын дутуу хийгдсэн ажлыг гүйцэтгэгч компаниар дахин гүйцэтгүүлэх албан шаардлагыг ЗДТГ-ыг Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс өгөв.

Аудитын илрүүлэлт:

- Баян-өндөр сумын Эрүүл мэндийн төвийн засварын ажлын төсөвт Гадна засал, бохир усны шаазан угаалтуур, шалны ажил, дээврийн ажил хийхээр төлөвлөсөн боловч аудитаар газар дээр нь очиж шалгахад төсвийн зориулалтыг зөвшөөрөлгүй өөрчилсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5⁷ дахь заалтыг зөрчсөн байна.

Иймд Баян-өндөр сумын Эрүүл мэндийн төвийн засварын ажлын тоо хэмжээ, зориулалтыг албан тушаалаа хэтрүүлсэн өөрчилсөн эмнэлгийн даргад хариуцлага тооцох, албан шаардлага хүргүүлж зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэв.

❖ Авто замын сан

Авто замын сангийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэхээр баталсан төсөл арга хэмжээнээс 853.1 сая төгрөгийн 14 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, 2,099.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлээгүй бөгөөд тайлант онд санхүүжилт олгоогүй байна.

Хүснэгт №9. Замын сангийн ажлын хэрэгжилт

№	Төсөл арга хэмжээний нэр	Нөхцөл байдал
1	Баянхонгор сумын Дунд захын гурван замын уулзвараас Доод захын гурван замын уулзвар хүртэл 0.5 км хатуу хучилттай авто замыг шинэчлэх Гэрээний дүн: 215.5 сая Гүйцэтгэгч: "Урагшлах Үе" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Баянхонгор сумын дунд захын 3 замын уулзвараас доод захын замын уулзвар хүртэл 0.5км хатуу хучилттай авто замыг шинэчилж замын хашлага тавих, асфальт бетоноор хучсан.
2	Баянхонгор сумын Цагдаагийн газраас Арван мянгатын 4 замын уулзвар хүртэл 0.45 км хатуу хучилттай авто замыг шинэчлэх Гэрээний дүн: 196.6 сая Гүйцэтгэгч: "Урагшлах Үе" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Цагдаагийн газраас арван мянгатын замын уулзвар хүртэл 0.45км хатуу хучилттай авто замыг шинэчилж замын хашлага тавих, асфальт бетоноор хучсан.
3	Баянхонгор сумын 3-р сургуулийн баруун урд уулзвараас Арван мянгатын бетон зам хүртэлх 1 км авто зам тавих	Зураг төсөв батлагдаагүй байснаас шалтгаалан худалдан авах ажиллагаа зарлагдаагүй удааширч оролцогч оролцоогүй.

⁶ “Барилгын ажлын ил, далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх

⁷ 16.5.5. батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

4	Баянхонгор сумын доторх эвдэрсэн талбайд замын нөхөөс хийх Гэрээний дүн: 40.0 сая Гүйцэтгэгч: "Их Богд зам" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Баянхонгор сумын нийтийн эзэмшлийн асфальт бетон замд 652.6м ² нөхөөсний ажил хийж гүйцэтгэсэн.
5	Баянхонгор сумын Арван мянгатын дөрвөн замын уулзвараас Хонгор хотхон хүртэлх 0.7 км явган зам шинээр тавих Гэрээний дүн: 119.4 сая Гүйцэтгэгч: "Буян арвижих од" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Баянхонгор сумын Арван мянгатын дөрвөн замын уулзвараас Хонгор хотхон хүртэлх 0.7 км явган зам явган хүний замыг шинээр хийсэн.
6	Зам арчилгаанд шаардлагатай давс худалдан авах Гэрээний дүн: 40.0 сая Гүйцэтгэгч: иргэн Н.Саранболд Гүйцэтгэл: 100 хувь	Баянхонгор тохижилт үйлчилгээний газарт нийлүүлсэн
7	Баянхонгор сумын 1-р багийн нийтийн эзэмшлийн зам талбайн засвар Гэрээний дүн: 20.0 сая Гүйцэтгэгч: "Энх цоо хишиг" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Баянхонгор сумын захын уулзварын баруун талд байрлах Майхан цахирын байрны голын авто зогсоолыг шинээр хийсэн байна. Ашиглах явцад бохирын шугам янзлахаар эвдэж хагарсан байна.
8	Баянхонгор сумын төв зам дагуух нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилтын ажил Гэрээний дүн: 20.0 сая Гүйцэтгэгч: "Тод тунгалаг тэмдэг" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Хэрэгжиж дууссан
9	Баянхонгор сумын авто замын тэмдэг, тэмдэглэгээг нэмэгдүүлэх Гэрээний дүн: 20.0 сая Гүйцэтгэгч: "Тод тунгалаг тэмдэг" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Баянхонгор сумын тэмдэг тэмдэглэгээ сэргээх ажилд 1000м ² талбайг термопластик будгаар будаж сэргээсэн,
10	Шаардлагатай сургууль, цэцэрлэгийн орчмын авто замыг стандартын тэмдэг тэмдэглэгээтэй болгох, камержуулалтыг сайжруулах Гэрээний дүн: 80.7 сая Гүйцэтгэгч: "Тод тунгалаг тэмдэг" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Шаардлагатай сургууль цэцэрлэгийн орчмын авто замыг стандартын тэмдэг тэмдэглэгээтэй болгох ажлын материал нийлүүлэх гэрээгээр Авто замын термопластик будаг шар, цагаан 19.5 тн, гэрэл ойлгогч цацлага 5тн, хурд сааруулагч 72ш, тэлэгч боолт 232ш ийг нийлүүлсэн.
11	Төв зам дагуу гэрэлтдэг явган хүний гарц суурилуулах Гэрээний дүн: 10.0 сая Гүйцэтгэгч: иргэн О.Эрдэнэбат Гүйцэтгэл: 100 хувь	Баянхонгор сумын 5 дугаар сургуулийн урд замын явган хүний гарц, 4-р сургуулийн арын зам дагуух явган хүний гарц дээр байршуулсан байна.
12	Баянхонгор аймаг дахь Иргэний нисэх буудлын нийтийн эзэмшлийн гадна авто зогсоолыг сайжруулах Гэрээний дүн: 20.0 сая Гүйцэтгэгч: "Их богд зам" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Нисэх буудлын хашаан доторх авто зогсоолын нөхөөс, шинээр асфальт бетон цутгах, тэмдэглэгээ хийсэн байна. 285м ² талбайг асфальтаар засварласан.
13	Өлзийт сумын төвд авто зогсоол байгуулах Гэрээний дүн 20.0 сая Гүйцэтгэгч: "Энх цоо хишиг" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Хэрэгжиж дууссан
14	Заг Байдрагийн голын эвдэрсэн хэсгийг засварлах Гэрээний дүн: 50.0 сая Гүйцэтгэгч: "Буянт хөрс наран" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Гүйцэтгэгч ажлаа хийгээгүй. Гүйцэтгэл олгоогүй.
15	Баянхонгор сумын 6 дугаар багын үерт эвдэрсэн замын засварын ажил Гэрээний дүн: 32.5 сая Гүйцэтгэгч: "Талын нөмөр" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Онцгой комиссын шийдвэрээр Өлзийт МСҮТ-ийн ард үерийн ус зайлуулах далан болон, үерийн ус хуримтлуулах цооног хийсэн
16	Эрдэнэцогт сумын Ямаан усны давааны үерт эвдэрсэн замын засварын ажил Гэрээний дүн: 39.4 сая Гүйцэтгэгч: "Марал гүн" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Аймгийн онцгой комиссын шийдвэрээр Эрдэнэцогт сумын ямаан усны давааны үерт эвдэгдсэн хэсгийн ажлыг сэргээн засах ажилд ухагдсан замыг дүүргэх, тэгшлэх ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Аудитаар төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг газар дээр нь очиж үзэхэд төлөвлөсөн техникийн тодорхойлолтын дагуу ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

2.2.3. Захиалагч, зохиогч үе шатны хяналтыг цаг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлсэн үү?

Аймгийн Засаг даргаас эрх шилжүүлсэн зарим засварын ажлуудад захиалагчийн зүгээс тавих хяналт сул байна.

Аудитын илрүүлэлт:

➤ Баян-өндөр сумын Эрүүл мэндийн төвийн засварын ажлын захиалагчийн хяналтыг холбогдох мэргэжлийн ажилтнаар хийлгээгүйгээс төсөвт тусгагдсанаас өөр ажлыг зөвшөөрөлгүй хийсэн. Мөн тус ажлыг хүлээн авах комисст мэргэжлийн шинжээч ороогүй байна.

Иймд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл арга хэмжээг гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналт, хүлээн авах улсын комисст мэргэжлийн шинжээчийг оруулж байх зөвлөмжийг сумдын Засаг дарга нарт өгөв.

Аймгийн Засаг даргаас эрх шилжсэн арга хэмжээнүүдэд захиалагчийн хяналт хийгдэхгүй орхигдох эрсдэлтэй байна. Тухайлбал.

Цагдаа, онцгой байдлын байрны засварын ажлууд хэдий бага төсөвтэй ч хяналт хийгээгүйгээс төсвийн хөрөнгийн үр ашиг бүрэн гараагүй байна.

Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж буй ГХБХБГ нь 2024 онд барилга угсралтын ажилд хяналтын нэг инженер, шугам сүлжээ дэд бүтэц хариуцсан нэг инженер аймгийн хэмжээнд улс, орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй 70 орчим барилга угсралтын ажилд хяналт хэрэгжүүлсэн бөгөөд 1 объектод дунджаар 3 удаа хяналт хэрэгжүүлэхэд 220 орчим удаагийн хяналт хийж байгаагаас үзэхэд хүний нөөцийн хүрэлцээ дутмаг байна.

Энэ нь цаашид чанаргүй барилга баригдах, төсөл арга хэмжээний төлөвлөсөн үр ашиг бүрэн гарахгүй байх үр дагавар үүсэж байна.

Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 2.9⁸-д заасны дагуу зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий хуулийн этгээдээр хяналтыг гүйцэтгүүлэх боломж байгааг Улсын төсвийн хөрөнгө оруулалтын аудитаар аймгийн Засаг даргад зөвлөмжөөр хүргүүлсэн.

БҮЛЭГ 3. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ ҮР ДҮНТЭЙ БАЙНА УУ? ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ ИРГЭДИЙН ТААТАЙ АМЬДРАХ ОРЧИНД ЭЕРЭГ НӨЛӨӨ ҮЗҮҮЛЖ БАЙНА.

3.1 Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний бүртгэл, ашиглалт хэвийн байна уу?

⁸ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах барилга байгууламжийн захиалагч нь Барилгын тухай хуулийн 37.2-т заасны дагуу барилга захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий төрийн өмчит хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх, эсхүл холбогдох чиглэлээр бүртгүүлсэн зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий хуулийн этгээдийг сонгон ажиллуулж болно.

3.1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар бий болсон зарим хөрөнгийн бүртгэл, ашиглалт хангалтгүй байна.

3.1.1. Хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан уу?

Орон нутгийн хөрөнгө оруулалтын 6,787.3 сая төгрөгийн 53 төсөл арга хэмжээнээс 5,445.9 сая төгрөгийн 40 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж дууссан бөгөөд аймгийн ИТХ-ын тогтоол болон хурлын даргын захирамжаар нийт 3,153.5 сая төгрөгийн 25 төсөл, арга хэмжээнд шийдвэр гарч ашиглагч байгууллагуудын хөрөнгийн бүртгэлд бүртгэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Харин үлдсэн 2,664.6 сая төгрөгийн 15 төсөл, арга хэмжээ оны эцэст болон 2025 он гарч хүлээн авснаас шалтгаалан хөрөнгийн бүртгэлд бүрээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4⁹ дэх заалтыг зөрчсөн байна.

Дээрх бүртгээгүй хөрөнгөнөөс комисс хүлээн авсан ч дахин засварлаж, гүйцэтгэх шаардлагатай 262.3 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээний шийдвэр гаргуулах хүсэлтийг аймгийн ОНӨГ захиалагчид буцаасан байна.

Иймд ажлаа дуусгаж холбогдох комисс хүлээн авч ашиглахад бэлэн болсон 2,402.3 сая төгрөгийн 12 төсөл арга хэмжээг эрх бүхий байгууллагаар шийдвэр гаргуулж, хөрөнгийн бүртгэлд бүртгэх албан шаардлагыг аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүртгүүлэв.

3.1.2. Хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг хэвийн ашиглаж байна уу?

Хөрөнгө оруулалтын үр дүнд нийт 5,064.9 сая төгрөгийн 27 төсөл, арга хэмжээг комиссоор хүлээлгэн өгсөн бөгөөд аудитаар газар дээр нь очиж шалгахад 4,714.8 сая төгрөгийн 26 төсөл, арга хэмжээний хүрээнд хийсэн ажлуудыг хэвийн ашиглаж байна.

Аудитын илрүүлэлт:

Бууцагаан сумын хуучин сургуулийн засварын ажлыг 356.3 сая төгрөгөөр “Түйн долгио” ХХК гүйцэтгэсэн бөгөөд тус сургуулийн барилга ашиглалтгүй байна.

Иймд тус барилгын ашиглалтыг эрх бүхий байгууллагаар шийдвэр гаргуулан ашиглалтыг сайжруулж, төсвийн хөрөнгийн үр ашгийг сайжруулах албан шаардлагыг аймгийн Боловсролын газарт хүртгүүлэв.

3.2. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ нь үр дүнгээ өгч иргэдийн амьдралд нөлөөлсөн үү?

3.2. Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж ашиглалтад орсон төсөл, арга хэмжээ нь хүүхдийн сурч, боловсрох болон иргэдийн ажиллаж, амьдрах орчинд эерэг нөлөө үзүүлж байна.

3.2.1. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн үү?

⁹ 13.4.Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.

Хөрөнгө оруулалтын үр дүнд хийж ашиглалтад орсон төсөл, арга хэмжээ нь орон нутгийн хөгжилд дараах байдлаар нөлөөлж байна. Үүнд:

- ✓ Сургуулийн өмнөх боловсролын 4 цэцэрлэгт засварын ажил хийснээр нийт 380 орчим хүүхдийн сурч хөгжих орчин сайжирсан бөгөөд бүрэн дунд боловсролын 4 сургуулийн их засварын ажлыг амжилттай гүйцэтгэснээр 1600 гаруй сурагч эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд суралцах нөхцөл бүрдсэн
- ✓ Сургуулийн 4 дотуур байрны засварын ажлыг хэрэгжүүлснээр 200 гаруй хүүхдийн амьдрах орчин сайжирч, эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд амьдран суралцах боломж бүрдсэн.
- ✓ Жаргалант сумын орон сууцны дунд байрлах нийтийн эдэлбэр газарт хүүхдийн тоглоомын талбай шинээр байгуулснаар сумын төвийн 100 орчим хүүхэд чөлөөт цагаа аюулгүй, зөв боловсон өнгөрөөх орчин бүрдсэн.
- ✓ Баянбулаг сум болон Шаргалжуут тосгоны спорт заалнуудад засварын ажил хийснээр 13-40 насны 1000 гаруй иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, биеийн тамир, спортоор хичээллэх боломжийг бодитоор нэмэгдүүлж орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, нийгмийн идэвхийг дэмжсэн.
- ✓ Цагдаа болон Онцгой байдлын албаны сум дахь нэгжүүдийн барилгын нөхцөлийг сайжруулснаар төрийн тусгай албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, иргэдийн аюулгүй байдлыг хамгаалах үйл ажиллагаанд зэрэг нөлөө үзүүлж байна
- ✓ Хүүхдийн Тэмүжин театр болон аймгийн ХДТ-т дээврийн болон сантехникийн засвар үйлчилгээ хийснээр соёлын үйлчилгээг тасалдалгүй хүртэх боломжтой болсон байна.

Харин тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 2,262.0 сая төгрөгийн 2 ТАХ-г хэрэгжүүлээгүйгээс дараах боломжийг алдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн гадна бохир усны шугам сүлжээний 22.0 сая төгрөгийн ажил хийгээгүйгээс 200 орчим хүүхэд төсвийн хөрөнгийн үр ашгийг хүртээгүй
- Хүрээмарал сумын цэцэрлэгийн барилгад шаардлагатай засварын ажлыг хийгээгүйгээс шалтгаалан 90 орчим хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд сурч хөгжих боломж хязгаарлагдсан.

Иймд орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээг цаг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

3.2.2. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний гүйцэтгэл үр дүн иргэдэд хүртээмжтэй ил тод байна уу?

Орон нутгийн төсөв болон замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг Шилэн дансны цахим хуудас болон Нээлтэй засаг Баянхонгор Facebook хуудас, Bayanhongor.gov.mn вэб сайтаар иргэд олон нийтэд ил тод мэдээлсэн байна.

Тухайлбал: Шилэн дансны цахим хуудсанд орон нутгийн төсөв болон замын сангаар хийгдсэн төсөл арга хэмжээнүүдийг байршуулсан байна.

✓ Замын ажил

Авто зам засвар, шинэчлэл
Гүйцэтгэгч байгууллага: Тендерийн мэдээлэлтэй хамт байршуулсан
Гүйцэтгэл: Төлөвлөгөө, зарцуулалт, гүйцэтгэлийн хувь

✓ Сургуулийн барилга, засвар

Ерөнхий боловсролын сургуулийн өргөтгөл, их засвар

Тендерийн мэдээлэл: Гэрээний дугаар, гүйцэтгэгч, гэрээний дүн

Баянхонгор: 2024 онд УЛСЫН ТӨСВИЙН 270 ГАРУЙ ТЭРЭУМЫН ӨРТӨӨР 51 ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ ХЭРГЭЖИЖ БАЙНА

115 ХТН ҮЭСЭН БАЙНА

Төрөл	Төлөөлөгч	Дүн	Төлөөлөгч	Төлөөлөгч	Төлөөлөгч	Төлөөлөгч	Төлөөлөгч	Төлөөлөгч	Төлөөлөгч
1	Төрийн өмчийн хэргийн газар	104	2024	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00
2	Төрийн өмчийн хэргийн газар	105	2024	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00
3	Төрийн өмчийн хэргийн газар	106	2024	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00
4	Төрийн өмчийн хэргийн газар	107	2024	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00
5	Төрийн өмчийн хэргийн газар	108	2024	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00
6	Төрийн өмчийн хэргийн газар	109	2024	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00
7	Төрийн өмчийн хэргийн газар	110	2024	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00
8	Төрийн өмчийн хэргийн газар	111	2024	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00
9	Төрийн өмчийн хэргийн газар	112	2024	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00
10	Төрийн өмчийн хэргийн газар	113	2024	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00
11	Төрийн өмчийн хэргийн газар	114	2024	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00
12	Төрийн өмчийн хэргийн газар	115	2024	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00
13	Төрийн өмчийн хэргийн газар	116	2024	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00
14	Төрийн өмчийн хэргийн газар	117	2024	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00
15	Төрийн өмчийн хэргийн газар	118	2024	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00
16	Төрийн өмчийн хэргийн газар	119	2024	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00
17	Төрийн өмчийн хэргийн газар	120	2024	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00	1,162,000,000.00

Аудитаар нийт 7,118.9 сая төгрөгийн зөрчил илрүүлж 42.4 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 7,076.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах 7 албан шаардлага өгч, зөрчлийг давтан гаргуулахгүй байх 4 зөвлөмжийг холбогдох байгууллага албан тушаалтнуудад хүргүүлэв.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Баянхонгор аймгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийг дунд хугацааны хөгжлийн бодлого, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөсөн байна.
2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийх төсөл, арга хэмжээний хэрэгцээ шаардлага, нийгмийн ач холбогдлыг эрэмбэлэхгүй байна.
3. Аймгийн ИТХ нь Төсвийн ерөнхийлөн захирагчаас өргөн барьсан төсвийг батлахдаа хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгээгүй, зураг төсөвгүй, хуульд заасан төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг оруулан баталсан байна.
4. Баянхонгор аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулсан байна.
5. Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж буй Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт хяналт хэрэгжүүлэх хүний нөөцийн хүрэлцээ дутмаг байгаагаас хяналтыг чанартай гүйцэтгэж чадахгүй, сумдад захиалагчийн хяналтыг гүйцэтгэх мэргэжлийн боловсон хүчин байхгүйгээс төсөл, арга хэмжээ чанаргүй, дутуу хийгдэж байна.
6. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар бий болсон зарим хөрөнгийн бүртгэл, ашиглалт хангалтгүй байна.
7. Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж ашиглалтад орсон төсөл, арга хэмжээ нь хүүхдийн сурч, боловсрох болон иргэдийн ажиллаж, амьдрах орчинд эерэг нөлөө үзүүлж байна.

-оОо-

ЗӨВЛӨМЖ:

НЭГ. БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯНХОНГОР ИТХ-Д ТОЛИЛУУЛАХ НЬ:

1. Төсвийн ерөнхийлөн захирагчаас өргөн барьсан төсөвт өөрчлөлт оруулан батлахдаа ТЭЗҮ хийгээгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг баталснаас хөрөнгө оруулалтын төлөвлөгөө тасарч төсвийн хөрөнгийн үр ашиг гарахгүй байна.

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

НЭГ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.МӨНХСАЙХАН ТАНАА:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг холбогдох хууль, журмын дагуу ач холбогдол, үр ашгийг дагуу эрэмбэлж байх
2. Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа Төрийн хэмнэлийн хууль болон бусад хууль тогтоомжоор заасан хугацаанд багтаан худалдан авах ажиллагааг зохион байгуулж байх.
3. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж аймгийн ИТХ-аар баталсан төсөл, арга хэмжээг тайлант хугацаанд нь багтаан бүрэн хэрэгжүүлж байх.

ХОЁР. СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ:

4. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа барилга, байгууламжийн гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналт, хүлээн авах улсын комисст мэргэжлийн шинжээчийг оруулж байх.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2025 оны 12 дугаар сарын 01-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

-оОо-